



ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2023 оны 03 сарын 17 өдөр

Дугаар А/ЧБ

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Нисэхийн эрүүл мэнд, сэргээн засах албаны хоол үйлдвэрлэлд шаардлагатай мах" нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны  
дарга:

С.Батхуяг

(Иргэний нисэхийн үндэсний төвийн Хөдөлмөрийн  
аюулгүй байдал, эрүүл ахуйн хэлтсийн дарга)

Гишүүд:

Б.Пүрэвтогтох

(Иргэний нисэхийн үндэсний төвийн Нисэхийн  
эрүүл мэнд, сэргээн засах албаны хоол  
үйлдвэрлэлийн мэргэжилтэн)

М.Оргил

("Сэтгэл зүй судалгаа, мэдээллийн төв" Төрийн  
бус байгууллагын гишүүн (тохиролцсоноор))

С.Цогзолмаа

("Үндэсний аж үйлдвэрлэлийн зөвлөл" Төрийн бус  
байгууллагын гишүүн (тохиролцсоноор))

Нарийн бичгийн  
дарга:

Б.Сумъяажав

(Иргэний нисэхийн үндэсний төвийн Хөрөнгө

оруулалт, захиалагчийн албаны Худалдан авах  
ажиллагааны тасгийн мэргэжилтэн)

2.Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хороо (С.Батхуяг)-нд, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Т.Батжаргал), Иргэний нисэхийн үндэсний төв (Н.Батсайхан)-д тус тус үүрэг болгосугай.

3.Тендер болон сонгон шалгаруулалттай холбоотой баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөх, тендерт оролцоход үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг гаргуулан Дотоод аудитын албанд хүргүүлэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Б.Сумъяажав)-д даалгасугай.

ДАРГА



Ч.МӨНХТУЯА